



**ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

48090 Мандалговь, Сайнцагаан сум  
Утас: 70592439, 70592208, 70593208  
Е-мэйл: dundgovi@audit.gov.mn

**САЙХАН-ОВОО СУМЫН МОНГОЛ  
АРДЫН НАМЫН ХОРООНД**

2020-07-30 № 121  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Орон нутгийн Хурлын 2020 оны сонгуульд оролцох Сайхан-Овоо сумын Монгол ардын намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны сонгуульд оролцох Сайхан-Овоо сумын Монгол ардын нам нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа-2050”-д нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын дүнгийн хамт Төрийн аудитын байгууллагад ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл**

Дундговь аймаг дахь Төрийн аудитын газар нь сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны сонгуульд оролцох нам, эвслийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817 - 6 : 2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817 - 8 : 2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2020-2022 оны төсвийн төсөөллийн тухай хууль, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа-2050”, холбогдох бусад байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг шалгуур болгосон.

**Дүгнэлт**

“Дундговь аймгийн Сайхан-Овоо сумын Монгол ардын нам” -ын сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3. дахь хэсэг,

0012020384


“Алсын хараа-2050”, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

“Сайхан-Овоо сумын Монгол ардын нам”-ын мөрийн хөтөлбөр /.....<sup>4</sup> хуудас/-ийг хавсаргав.

Хувийг: Сайхан-Овоо сумын сонгуулийн хороонд

Хавсралт <sup>4</sup> . . . хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



П.ТӨВСАНАА



2020 ОНЫ АЙМАГ, НИЙСЛЭЛ, СУМ ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН  
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН СОНГУУЛЬД ОРОЛЦОХ ДУНДГОВЬ  
АЙМГИЙН САЙХАН-ОВОО СУМЫН МОНГОЛ АРДЫН НАМЫН  
МӨРИЙН ХӨТӨЛБӨР



УРИА: УЧИРАА БИД ОЛЛОО

УРАГШЛУУЛАХЫН ТӨЛӨӨ ХҮЧЭЭ НЭГТГЭЭ  
САЙХАН АМЬДРАЛЫН ТӨЛӨӨ  
САЙХАН-ОВООЧУУДАА ХҮЧЭЭ НЭГТГЭЭ

**ДУНДГОВЬ АЙМГИЙН САЙХАН-ОВОО СУМЫН ИРГЭДИЙН  
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН СОНГУУЛЬД МОНГОЛ АРДЫН НАМААС  
ДЭВШҮҮЛЭХ МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

УРИА:

- УЧИРАА БИД ОЛЛОО  
УРАГШЛУУЛАХЫН ТӨЛӨӨ ХҮЧЭЭ НЭГТГЭЭ
- САЙХАН АМЬДРАЛЫН ТӨЛӨӨ  
САЙХАН-ОВООЧУУДАА ХҮЧЭЭ НЭГТГЭЭ

“Алсын хараа-2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого, “Дундговь аймгийн нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх 2018-2028 дунд хугацааны хөгжлийн хөтөлбөр”, “Монгол Ардын Намын 2020-2024 оны мөрийн хөтөлбөр” зэрэг бодлогын баримт бичгүүдэд суурилсан мөрийн хөтөлбөрийг 8 үндсэн бүлэг, 52 төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлж ажиллана.



**1.Хүний хөгжлийн бодлогын хүрээнд**

- 1.1. “Амар амгалан гэр бүл” багц сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 1.2. “Удамт Малчин” сумын малчдын уулзалт 2 жилд 1 удаа зохион байгуулна.
- 1.3. Эмэгтэйчүүдийн чуулга уулзалтыг зохион байгуулна.
- 1.4. Залуучуудын байгууллагын үйл ажиллагааг дэмжин чуулга уулзалтыг жил бүр зохион байгуулна.
- 1.5. Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ.
- 1.6. Иргэд, малчдад цахим орчинд болон хөрөнгийн биржээр дамжуулан өрхийн орлогоо нэмэгдүүлэх сургалтыг зохион байгуулна.
- 1.7. Нутгийн залуу боловсон хүчнийг бэлтгэх, ажлын байраар хангах.

**2.Эдийн засгийн салбарын хүрээнд**

- 2.1. Төрийн болон орон нутгийн өмчийн ашиглалт хамгаалалтыг сайжруулж, тэдгээрийн бүртгэл, мэдээлэл, үнэлгээ тайланг ил тод нээлттэй болгож, өмч эзэмшигчдийн хариуцлагыг сайжруулах.
- 2.2. Орон нутгийн төсвийн орлого, зарцуулалтанд тавих иргэдийн оролцоог нэмэгдүүлж иргэдэд ил тод байлгана.
- 2.3. Татварын оновтой бодлогыг хэрэгжүүлж, сумын төсвийн орлогыг нэмэгдүүлж орон нутгийн санхүүгийн чадавхийг сайжруулна.

**3.Байгаль орчны салбарын хүрээнд**

- 3.1. “Ногоон хэрэм” үндэсний хөтөлбөр болон бусад төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлж сумын ногоон байгууламжийн тоог 3 дахин нэмэгдүүлнэ.
- 3.2. “Ногоон сум” хөтөлбөр батлуулан хэрэгжүүлнэ.
- 3.3. “Орхон-Онги” гол төслийг дэмжин ажиллана.
- 3.4. “Хоггүй цэвэрхэн сум” хөдөлгөөн өрнүүлж зориулалтын бус газар хог хаяхгүй дадал хэвшлийг төлөвшүүлэх, хөдөөгийн хур хогуудыг цэвэрлэнэ.

*Signature*

- 3.5. Сумын төвийн газрыг эдийн засгийн эргэлтэнд оруулж нээлттэй, өрсөлдөөний зарчмаар олгоно.
- 3.6. Брагри Ёнзон хамба Дамцагдоржийн ойг тэмдэглэх, төрсөн газарт гэрэлт хөшөө босгоно.
- 3.7. Өгөөдэй хааны өвлийн ордон Шаазант хотын түүхийг судлан дэлгэрүүлэх.

#### **4. Дэд бүтэц, аялал жуулчлалын салбарын хүрээнд**

- 4.1. Онгийн голын гүүр барьж ашиглалтанд оруулна.
- 4.2. Цахилгаан шугамын дэд станцын хүчин чадлыг нэмэгдүүлж, 04-ын шугамын өргөтгөл хийнэ.
- 4.3. Сумын бахархал, онцлогийг харуулсан “Түүхт Сайхан-Овоо” аялал жуулчлалын цогцолбор шинээр барина.
- 4.4. Гэр бааз байгуулах иргэд, малчдыг бодлогоор дэмжиж ажиллана.
- 4.5. Сумын төвийн айл өрхийг дулаан, цэвэр, бохиртой болгох ажлын эхлэлийг тавьж мэргэжлийн байгууллагаар ТЭЗҮ-г хийлгүүлэх.
- 4.6. Сумын төвийн иргэд, төрийн албан хаагчдыг хямд орон сууцаар хангах ажилд хувийн хэвшилтэй хамтран ажиллах.
- 4.7. Ахар, Хадан хошуу хороололын худгуудад цэвэршүүлэх төхөөрөмж суурилуулан ухаалаг худаг болгох.
- 4.8. Сумын төвийн урд, зүүн лагериудад гэрэлтүүлэг тавина.



#### **5. Хөдөө аж ахуйн салбарын хүрээнд**

- 5.1. “Хөдөө аж ахуйг хөгжүүлэх бодлого” сумын хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлж, бэлчээрийн даацад тохирсон уламжлалт мал аж ахуйг эдийн засгийн үр ашигтай эрхлэх бодлого барина.
- 5.2. Стандарт шаардлагыг хангасан мал нядлах цэгийг байгуулан, эрүүл ахуйн шаардлага хангасан мах, махан бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэх.
- 5.3. Малыг ээмэгжүүлэн бүртгэлжүүлж, эрүүлжүүлэх, гарал үүсэл нь тодорхой мах, махан бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэх боломжийг бүрдүүлнэ.
- 5.4. Арьс, шир боловсруулах анхан шатны цехтэй болох.
- 5.5. Газар тариалан эрхлэгчдийг дэмжиж, төмс хүнсний ногооны хэрэглээний 50%-аас доошгүй хувийг орон нутгаас хангах.
- 5.6. Мал эмнэлэгийн үйлчилгээний чанарыг сайжруулах, хувийн мал эмнэлэг ажиллуулах хүсэлтэй эмч, мэргэжилтэнийг дэмжих, мал, амьтны гаралтай халварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрүүл бүс нутаг болгох.
- 5.7. Баг тус бүрт залуу малчдыг дэмжих санг “Зах зээл ба бэлчээрийн удирдлага” “Ногоон алт” зэрэг төсөл хөтөлбөрүүд болон малчдын оролцоотой бий болгох.
- 5.8. Сайхан-Овоо сумын хөдөө аж, ахуйн гаралтай чанарын шаардлага хангасан бүтээгдэхүүнийг төв суурин газрын /хот, аймаг/ зах зээлд нийлүүлэх нэрийн дэлгүүр байгуулахад дэмжлэг үзүүлж зээл тусламжинд хамруулах
- 5.9. Сумын бизнес хөгжлийн төвийг тогтмол үйл ажиллагаанд оруулах.

*Тэмцэ*

- 5.10. Шилмэл мал, цагаан идээний болон жижиг дунд үйлдвэр эрхлэгчдийн бүтээгдэрүүний үзэсгэлэн худалдааг жил бүр зохион байгуулах.
- 5.11. Инженерийн хийцтэй гүн өрмийн болон энгийн уурхайн худаг сэргээн засварлах, шинээр гаргах ажлыг зохион байгуулна.
- 5.12. Зуны хүлэмжийн аж ахуйг дэмжиж төмс хүнсний ногоо тариалалтыг нэмэгдүүлэн



### **6.Боловсролын салбарын хүрээнд**

- 6.1. ЕБСургуулийн 320 хүүхдийн хичээлийн шинэ байр, спорт заал барих
- 6.2. ЕБСургуулийг 12 жилийн сургалттай сургууль болгох.
- 6.3. Нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх, орчинг бүрдүүлэх.
- 6.4. Сургуулийн өмнөх боловсролын байгууллагыг үйл ажиллагааг дэмжиж, хамран сургалтыг нэмэгдүүлнэ
- 6.5. ЕБСургуулийн сурагчдын өөрөө удирдах байгууллагын дэмжин төлөвшүүлж, хүүхдийн багаас зөв дадал хэвшилд сургах.
- 6.6. “Шатар”, “Шагай харваа” дэд хөтөлбөрүүд боловсруулан хэрэгжүүлэх.
- 6.7. ЕБСургуулийн гадна хөлбөмбөгийн талбай байгуулна.

### **7.Эрүүл мэндийн салбарын хүрээнд**

- 7.1. Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлж, архины хэрэглээг багасгах, хорт зуршлыг арилгах чиглэлээр төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллана.
- 7.2. Эрүүл мэндийн төвийг шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах, өвчтөний онош, зургийг цахим орчинд нарийн мэргэжлийн эмчээс зөвлөгөө авч эмчилэх боломж нөхцөлөөр хангана.
- 7.3. Иргэдэд эрүүл аж төрөх хандлагыг төлөвшүүлж, дундаж наслалтыг нэмэгдүүлнэ.
- 7.4. Иргэдийн идэвхтэй хөдөлгөөнийг дэмжин, байгууллага бүрт унадаг дугуйн зогсоол бий болгох, унадаг дугуйтай иргэдийн тоог нэмэгдүүлнэ.

### **8. Нутгийн удирдлага**

- 8.1. Нутаг дэвсгэрийн хөгжлийн төвлөгөөг боловсруулах.
- 8.2. Аялал жуулчлалын гол зам дайран өнгөрдөг боломжийг үндэслэн “100 жишиг сум” хөтөлбөрт хамруулах.
- 8.3. Сумын 100 жилийн ойг угтсан ажлын төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлнэ.
- 8.4. Сум тохижилтын журам боловсруулж сумын төвийн хог цуглуулах, тээвэрлэх ажлыг бие даан хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлнэ.

*Jimmy*